



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 22 өдөр

Дугаар А/397

Номгон

Төрийн өмчийн эзэмшилд байгаа барилгат
байгууламжийн ашиглалтын байдалд үнэлгээ
өгөх ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2 /а/, 29.1.2 /б/, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Төрийн өмчийн эзэмшилд байгаа ашиглалтын хугацаа нь дууссан буюу эсхүл шинэ барилга байгууламжтай болсны улмаас ашиглах боломжгүй болсон цаашид засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг акт тогтоон устгах ажлын хүрээнд буулгах барилгын жагсаалт гаргах, тухайн хөрөнгүүдийн буулгалтын зардлыг улсын төсвийн хөрөнгөөр шийдвэрлүүлэх эрэмбэ гаргах” чиглэл бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай .

Ажлын хэсгийн дарга: Т.Хишигбаатар –Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд Т.Норовринчин – Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн барилга, дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн

Ч.Сарайдамба – Мэргэжлийн хяналтын газрын барилгын хяналтын улсын байцаагч

Н.Мөнхбаатар – Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын барилга хот байгуулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн

С.Хүрэлхуяг – Аймгийн Ерөнхий архитектор

Л.Доржханд – Орон нутгийн өмчийн газрын өмч хариуцсан ахлах мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга: О.Эрдэнэ-Оюун - Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн


2. “Төрийн өмчийн эзэмшилд байгаа ашиглалтын хугацаа нь дууссан буюу эсхүл шинэ барилга байгууламжтай болсны улмаас ашиглах боломжгүй болсон

521011001

2.

цаашид засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг акт тогтоон устгах ажлын хүрээнд буулгах барилгын жагсаалт гаргах, тухайн хөрөнгүүдийн буулгалтын зардлыг улсын төсвийн хөрөнгөөр шийдвэрлүүлэх эрэмбэ гаргах” чиглэл бүхий ажлын хэсгийн тайланг 07 дугаар сарын 01-ний дотор танилцуулахыг ажлын хэсэг (Т.Хишигбаатар)-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг орлогч (Б.Батсуурь)-д даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН